



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 1 дүгээр сарын 16-ны  
өдөр

Улаанбаатар хот

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ**

#### **1 дүгээр зүйл.**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг баталсантай холбогдуулан дор дурдсан иргэдийн тэтгэврийг зогсоосугай:

1/ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан тэтгэвэр авах нөхцөл, болзлыг хангаагүй;

2/ ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доош хувиар алдаж, тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа;

3/ */Энэ заалтыг 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

#### **2 дугаар зүйл.**

Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн дагуу тэтгэвэр нь зогсоогдох иргэдийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан тэтгэвэр авах нөхцөл, болзлыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчдын тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг зохицуулсан хууль батлагдаж хүчин төгөлдөр болох хүртэл хэвээр хэрэглэж байхаар тогтоосугай.

*/Энэ зүйлд 1997 оны 5 дугаар сарын 22, 1997 оны 12 дугаар сарын 26, 1999 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн хуулиудаар тус тус өөрчлөлт орсон/*

#### **3 дугаар зүйл.**

Нийгмийн халамжийн тэтгэвэр болон хүүхэд асарсны тэтгэмжийг Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр шинэчлэн тогтоосугай.

**4 дүгээр зүйл.**

1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу 5 жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дундажаар бодож шинэчлэн тогтоосугай.

**5 дугаар зүйл.**

Үнэ, тариф, амьжиргааны өртгийн өөрчлөлт, тэтгэвэр бодох цалин, хөдөлмөрийн хөлсний хоорондын зохистой харьцааг Засгийн газраас тогтоож мөрдүүлсүгэй.

**6 дугаар зүйл.**

Энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**  
**ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

---